

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3б хавсралтад заасан загвар хүснэгтээр тайлагнав.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2022 оны жилийн эцсийн байдлаар)

2022.12.25

Д/д	Зорилт (бодлогын үндэслэл)	Төсөл, арга хэмжээ	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Шаардлагатай нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг), эх үүсвэр	Суурь түвшин	2022 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц, хэрэгжилтийн хувь
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	
1	2	3	4	5	6	7	8	9	10
Бүлэг 4. Засаглалын бодлого									
Зорилго 4.1. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.									
4.1.19	МУТЖҮЧ-5.1.1, ЗГҮАХ-4.4.10	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	46.0 Улсын төсөв	Хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан. Холбогдох судалгаа хийгдсэн. Төрийн өмчит компанийн засаглалын дундаж	Хууль батлагдсан байна. 3 журмын төслийг баталж мөрдүүлсэн байна. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 65-70 хувьд	-	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны болон 10-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн ЗГ-1/146 дугаартай албан бичгээр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрийн чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг

		Хуралд өргөн мэдүүлэх			үнэлгээ 53.9 хувь.	хүрсэн байна.		<p>хэлэлцээд Үзэл баримтлалын хүрээнд дэмжин анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, журам, дүрмийг боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээг авч, холбогдох зохицуулалтыг шинээр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжтой нийцүүлэх ажлуудыг хийв. Энэ хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> – Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-ыг ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөж байна. – Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажилд ашиглагдах аргачлал маягыг ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор батлуулсан. – Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журмыг ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, мөрдүүлэв. – Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Автомашин дуудлага үйлчилгээний нийтлэг журам"-ын төслийг ЗГХЭГ-т, Автомашин дуудлагын үйлчилгээний тариф, зардлын норм, нормативд тусгах саналыг Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.
--	--	-----------------------	--	--	--------------------	---------------	--	--

									<p>УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай анхдагч хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажиллаж байна. Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Б.Энхбаярын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу гишүүд тодорхой үүрэг, чиглэлээр ажиллаж байна.</p> <p>Компанийн засаглалын олон улсын туршлагыг судлах хүрээнд Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөлтэй ТӨБЗГ-т уулзалт зохион байгуулж, Сингапур улсын компанийн засаглалын сайн туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх, тус улсын Темасек холдинг корпорацтай холбох асуудлаар яриа хэлцэл хийсний дагуу тус байгууллагатай цахимаар холбогдох бэлтгэл ажлыг хангах, санал солилцох чиглэлээр ажиллав. БНХАУ, Сингапур улстай санамж бичиг байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>Төрийн өмчит 9 компанид хийсэн компанийн засаглалын 2022 оны үнэлгээ дунджаар 69.0 хувь байна. Хэрэгжилтийн хувь: 90%</p>
Зорилго 4.4. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.									
4.4.1	5.2.19, МУТЖҮЧ- 5.1.1, ЗГҮАХ- 4.4.10	Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж,	Ерөнхий сайд	25.0 Улсын төсөв	2016 онд улсын үзлэг, тооллого зохион байгуулсан.	Улсын үзлэг, тооллого зохион байгуулсан байна.	301.0	300.3 (өссөн дүн)	Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай" 9 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажил 2022 оны турш зохион байгуулагдав. Улсын үзлэг, тооллого явуулахад шаардлагатай нийт 301.0 сая төгрөгийн төсөв 2022 оны улсын төсөвт

		<p>төрийн өмчид бүртгэл хийж, хяналт тавих</p>					<p>тусгагдан батлагдсан бөгөөд 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 300.3 сая төгрөгийг тоног төхөөрөмж, программ хангамж, түүний зөвшөөрөл, томилолтын зардал, хэвлэлийн үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.</p> <p>Улсын үзлэг, тооллогын мэдээллийн системийн техник болон программ хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд нийт 29.6 сая төгрөгийн төсвийг зарцуулж, бүртгэл, дүн мэдээг нэгтгэх боломжийг бүрдүүлснээр төрийн болон орон нутгийн өмчит 6613 хуулийн этгээдийн улсын үзлэг, тооллогын дүн мэдээг хянан баталгаажуулах ажлыг хийж дууссан. Улсын үзлэг, тооллогод нийт 91.7 их наяд төгрөгийн хөрөнгө хамрагдсан байна.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг, тооллогын нэгдсэн дүнг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.</p> <p>Нийслэл болон 21 аймагт байгаа төрийн өмчит нийт 1030 хуулийн этгээдтэй байгуулсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2021 оны биелэлтийг дүгнэв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал"-ын 4.1-д заасны дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүн, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулгыг бэлтгэж, 12 дугаар сарын 27-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ээлжит хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилтийн хувь: 100%</p>
--	--	--	--	--	--	--	--

Товчилсон үгийн жагсаалт:

МУТЖҮЧ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

ЗГҮАХ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 2 арга хэмжээг хяналтад авч, жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнав.

Нийт 2 арга хэмжээний дундаж үнэлгээ - 95.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”. Хэрэгжилтийн явц (заалт бүрийн)-д тодорхой ахиц гарсан байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЦЭРЭНЛХАМ